



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/108

Дархан сум

Бог малын мялзан өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/135 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/471 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний нийт бог малыг хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгэхийг Мал эмнэлгийн нэгжийн захирлууд "Мэргэн хошуу" Ж.Намхайдорж, "Дархан мандал" Г.Содном, "Чандмань мал сүрэг" Б.Өсөхжаргал, "Буйлан талын сүрэг" Э.Чулуунтогтох нарт үүрэг болгосугай.

3.Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа хоолойг бэлтгүүлэхийг багийн Засаг дарга нарт, урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг ханган ажиллахыг Мал эмнэлгийн нэгжийн захирлууд "Мэргэн хошуу" Ж.Намхайдорж, "Дархан мандал" Г.Содном, "Чандмань мал сүрэг" Б.Өсөхжаргал, "Буйлан талын сүрэг" Э.Чулуунтогтох нарт тус тус үүрэг болгосугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч (Б.Ганжууржав)- д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Г.БАТБОЛД

